



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/199/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

“Си Пи Ти Эй Аудит” ХХК-ийн захирал: Ч.Энхчимэг
Утас: 99046494 Цахим хаяг: enkhchimeg@cptaaudit.mn

Гүйцэтгэсэн аудитор: М.Мөнхтөгс
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/205
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ДАВААЖАВ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар нийт 13,490.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авч бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар 10,938.6 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой алдааг залруулж, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж хүргүүллээ.

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэг нь Боловсролын газрын даргаар батлуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 99.3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>136,723,824.99</u>	<u>70,269,930.11</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	78,057,254.09	11,174,688.48
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	78,057,254.09	11,174,688.48
3121	Төгрөг	78,057,254.09	11,174,688.48
31211	Төрийн сангийн харилцах	78,057,254.09	11,174,688.48
33	АВЛАГА	1,378,156.10	00.00
335	Бусад авлага	1,378,156.10	00.00
3351	Байгууллагаас авах авлага	1,378,156.10	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	57,288,414.80	59,095,241.63
351	Түүхий эд материал	1,561,521.00	1,203,475.00
35130	Эм боох материал	1,561,521.00	1,203,475.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	9,665,305.10	11,118,905.10
354	Хангамжийн материал	46,061,588.70	46,772,861.53
35410	Бичиг хэргийн материал	252,100.00	35,100.00
35420	Аж ахуйн материал	27,047,020.00	27,842,020.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	7,580,000.00
35450	Барилгын засварын материал	4,919,250.00	3,484,000.00
35460	Хүнсний материал	13,310,818.70	7,299,341.53
35470	Бусад хангамжийн материал	532,400.00	532,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,003,685,987.83</u>	<u>988,679,026.06</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,003,685,987.83	988,679,026.06
392	Биет хөрөнгө	979,957,987.83	964,951,026.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,112,189,086.00	1,112,189,086.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-196,169,455.35	-222,987,002.79
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-391,666.67	-5,091,666.71
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	60,896,705.00	92,532,347.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-26,723,756.39	-40,541,804.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,355,105.61	22,575,105.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,780,480.37	-20,037,489.13
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,450,000.00	5,450,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,640,000.00	-2,910,000.08
39217	Ном	272,450.00	272,450.00
393	Биет бус хөрөнгө	23,728,000.00	23,728,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	23,728,000.00	23,728,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,140,409,812.82</u>	<u>1,058,948,956.17</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>6,221,105.41</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	6,221,105.41
413	Өглөг	00.00	6,221,105.41
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	2,096,105.41
4136	Бусад өглөг	00.00	4,125,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	4,125,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,140,409,812.82</u>	<u>1,052,727,850.76</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,140,409,812.82	1,052,727,850.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	94,534,205.00	94,534,205.00

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51101	Өмч: - төрийн	94,534,205.00	94,534,205.00
512	Хуримтлагдсан үр дүн	956,251,638.74	868,569,676.68
51210	Өмнөх үеийн үр дүн	956,251,638.74	956,251,638.74
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-87,681,962.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	89,623,969.08	89,623,969.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,140,409,812.82	1,058,948,956.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	777,886,195.00	872,317,142.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,437,795.00	34,245,542.50
120	Нийтлэг татварын бус орлого	51,437,795.00	34,175,542.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,108,395.00	34,175,542.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	44,073,395.00	34,175,542.50
120009	Бусад орлого	7,329,400.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	70,000.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	726,448,400.00	838,071,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	686,448,400.00	796,419,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	686,448,400.00	796,419,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40,000,000.00	41,652,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,000,000.00	41,652,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	778,409,007.49	959,999,104.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	778,409,007.49	959,999,104.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	776,843,280.55	959,838,891.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	565,068,165.79	720,507,270.83
210101	Үндсэн цалин	369,415,279.17	461,828,224.72
210102	Нэмэгдэл	174,881,095.37	220,186,646.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	21,265,000.00
210104	Урамшуулал	20,771,791.25	17,227,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,163,600.00	91,374,648.76
210201	Тэтгэврийн даатгал	49,071,300.00	61,197,932.03
210202	Тэтгэмжийн даатгал	5,773,100.00	7,263,795.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,886,500.00	5,631,570.63
210204	Ажилгүйдлийн даатгал	2,886,500.00	3,446,937.07
210205	Эрүүл мэндийн даатгал	11,546,200.00	13,834,413.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,350,873.06	31,117,817.15
210301	Гэрэл, цахилгаан	4,934,273.06	6,421,717.15
210302	Түлш, халаалт	21,916,600.00	22,086,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,500,000.00	2,609,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,752,029.00	13,035,400.00
210401	Бичиг хэрэг	4,949,950.00	4,794,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,265,379.00	2,429,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,536,700.00	5,811,200.00
2105	Нормативт зардал	44,204,109.78	42,848,230.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	129,000.00	358,046.00

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	44,075,109.78	42,490,184.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,151,250.00	6,199,220.00
210604	Урсгал засвар	9,151,250.00	6,199,220.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,386,000.00	1,422,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,386,000.00	1,422,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,767,252.92	53,333,404.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,908,800.00	3,916,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,870,500.00	1,554,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,987,952.92	47,862,604.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,565,726.94	160,212.85
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,565,726.94	160,212.85
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,565,726.94	160,212.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-522,812.49	-87,681,962.06
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,192,900.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,192,900.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,192,900.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-2,715,712.49	-87,681,962.06

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,534,205.00	89,623,969.08	958,967,351.23	1,143,125,525.31
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,534,205.00	89,623,969.08	958,967,351.23	1,143,125,525.31
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,715,712.49	-2,715,712.49
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,534,205.00	89,623,969.08	956,251,638.74	1,140,409,812.82
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,534,205.00	89,623,969.08	956,251,638.74	1,140,409,812.82
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-87,681,962.06	-87,681,962.06
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,534,205.00	89,623,969.08	868,569,676.68	1,052,727,850.76

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	726,483,400.00	838,141,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.00	70,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	70,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	70,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	726,448,400.00	838,071,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	686,448,400.00	796,419,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	686,448,400.00	796,419,600.00

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40,000,000.00	41,652,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,000,000.00	41,652,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	745,082,521.89	901,384,165.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	745,082,521.89	901,384,165.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	743,516,794.95	901,223,952.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	566,446,321.89	722,619,618.75
210101	Үндсэн цалин	369,415,279.17	446,192,183.62
210102	Нэмэгдэл	176,259,251.47	232,626,029.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	22,217,087.03
210104	Урамшуулал	20,771,791.25	21,584,318.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,163,600.00	85,788,039.33
210201	Тэтгэврийн даатгал	49,071,300.00	57,055,827.16
210202	Тэтгэмжийн даатгал	5,773,100.00	7,053,612.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,886,500.00	3,613,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,886,500.00	3,613,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,546,200.00	14,452,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,434,273.06	37,631,217.15
210301	Гэрэл, цахилгаан	4,934,273.06	6,421,717.15
210302	Түлш, халаалт	20,000,000.00	28,600,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,500,000.00	2,609,500.00
2105	Нормативт зардал	43,229,600.00	35,078,707.53
210502	Хоол, хүнс	43,229,600.00	35,078,707.53
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,350,000.00	3,860,570.00
210604	Урсгал засвар	8,350,000.00	3,860,570.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,586,400.00	1,422,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,586,400.00	1,422,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,306,600.00	14,822,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,490,700.00	12,744,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,815,900.00	2,078,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,565,726.94	160,212.85
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,565,726.94	160,212.85
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,565,726.94	160,212.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-18,599,121.89	-63,242,565.61
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,332,000.00	3,640,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,332,000.00	3,640,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,332,000.00	3,640,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,332,000.00	3,640,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2,332,000.00	-3,640,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-20,931,121.89	-66,882,565.61
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	98,988,375.98	78,057,254.09
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	78,057,254.09	11,174,688.48

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	872,390,600.00	796,489,600.00	27,845,300.00	91.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	872,390,600.00	796,489,600.00	69,497,300.00	91.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	865,986,900.00	796,489,600.00	69,497,300.00	92.0
131002	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	6,403,700.00	0.00	6,403,700.00	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	872,390,600.00	863,372,165.61	(32,473,352.76)	99.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	872,390,600.00	863,372,165.61	(32,473,352.76)	99.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	872,390,600.00	863,372,165.61	(32,473,352.76)	99.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	722,074,000.00	722,619,618.75	(545,618.75)	100.1
210101	Үндсэн цалин	454,200,300.00	446,192,183.62	8,008,116.38	98.2
210102	Нэмэгдэл	254,168,600.00	232,626,029.35	21,542,570.65	91.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	22,217,087.03	(22,217,087.03)	
210104	Урамшуулал	13,705,100.00	21,584,318.75	(7,879,218.75)	157.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,760,600.00	85,788,039.33	3,972,560.67	95.6
210201	Тэтгэврийн даатгал	60,877,700.00	57,055,827.16	3,821,872.84	93.7
210202	Тэтгэмжийн даатгал	7,220,600.00	7,053,612.17	166,987.83	97.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,610,400.00	3,613,100.00	(2,700.00)	100.1
210204	Ажилгүйдлийн даатгал	3,610,400.00	3,613,100.00	(2,700.00)	100.1
210205	Эрүүл мэндийн даатгал	14,441,500.00	14,452,400.00	(10,900.00)	100.1
2105	Нормативт зардал	37,821,600.00	35,078,707.53	2,742,892.47	92.7
210502	Хоол, хүнс	37,821,600.00	35,078,707.53	2,742,892.47	92.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,682,900.00	2,682,900.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,682,900.00	2,682,900.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,051,500.00	17,202,900.00	2,848,600.00	85.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,053,100.00	13,561,200.00	2,491,900.00	84.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,998,400.00	3,641,700.00	356,700.00	91.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	78,057,254.09	(78,057,254.09)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	11,174,688.48	(11,174,688.48)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	22.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.0

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	-	100.0
--------	-----------------	-------	-------	---	-------

2.6 Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41,652,000.00	41,491,787.15	160,212.85	99.6
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	41,652,000.00	41,491,787.15	160,212.85	99.6
132001	Орон нутгийн төсвөөс	41,652,000.00	41,491,787.15	160,212.85	99.6
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,652,000.00	41,491,787.15	160,212.85	99.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,652,000.00	41,491,787.15	160,212.85	99.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,652,000.00	41,491,787.15	160,212.85	99.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,800,000.00	37,631,217.15	168,782.85	99.6
210301	Гэрэл, цахилгаан	7,000,000.00	6,421,717.15	578,282.85	91.7
210302	Түлш, халаалт	28,600,000.00	28,600,000.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,200,000.00	2,609,500.00	(409,500.00)	118.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,852,000.00	3,860,570.00	(8,570.00)	100.2
210604	Урсгал засвар	3,852,000.00	3,860,570.00	(8,570.00)	100.2

3. Аудитын илрүүлэлт

3.1 Аудитын залруулга

Аудитаар нийт 10,938.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Бодогдсон цалингийн цэс, журнал бичилттэй 10,938.6 мянган төгрөгийн зөрүүтэй

3.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

3.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

3.4 Зөвлөмж

Илрүүлэлт:

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээнээс 18,891.8 мянган төгрөгийн зарлагын мэдээллийг зөрүүтэй байршуулсан зөрчил илэрсэн. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” дахь заалт болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн ил тод байдлыг хангаж, Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн, үнэн зөв мэдээлж ажиллах.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Дээрх төлбөрийн актыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын www.Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн тооцоо, Ерөнхий журналын бичилтийг зөрүүтэй тайлагнасан	1	10,938.6			1	10,938.6	1	10,938.6		
ДҮН	1	10,938.6			1	10,938.6	1	10,938.6		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны цахим мэдээллийн санд 18,891.8 мянган төгрөгийн зарлагын мэдээллийг илүү мэдээлсэн	1	0.0						1	0.0
Дүн	1	0.0						1	0.0

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								